



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлд:

Х.29. ХЭЛЭЛЦСЭН нь: Дахин төлөвлөлтийн тухай

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 ширхэг агуулахын зориулалттай барилгыг дахин төлөвлөлтөд хамруулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2023 онд Тээвэрчдийн ордон барих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолын дагуу Баянзүрх дүүрэг, 39 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 3 агуулахын зориулалттай барилгыг “МИАТ” ТӨХК-аас төлбөр төлөх нөхцөлтэйгөөр шилжүүлэн авсан.

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 39 дүгээр хороонд байрлалтай, 0000202427 дугаартай эрхийн гэрчилгээтэй, 9046 м.кв талбай бүхий газарт шинэ оффисын барилга барихаар төлөвлөж зураг төсөл, төсвийг хийсэн байна.

Иймд “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилд байгаа дээрх газарт байрлах үл хөдлөх хөрөнгийг дахин төлөвлөлтөд оруулан, оронд нь төрийн өмчийн шинэ оффисын зориулалттай барилга барихыг дэмжих нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

